

БАГА ХЭМЖЭЭНИЙ ЦӨМИЙН МАТЕРИАЛЫН ШИНЭЧИЛСЭН ПРОТОКОЛЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод нийцсэн эсэх, зорилгод хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэх, хуулийн төсөл нь ойлгомжтой, зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг үнэлж, төсвөөс гарах зардлын тооцоог хийж, тэдгээрийн үр дүнд үндэслэн анхаарах, өөрчлөх шаардлагатай зохицуулалтын талаар хуулийн төсөл боловсруулагчид зөвлөмж өгсөн.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Ойлгомжтой байдал
2. Харилцан уялдаа

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах үүднээс холбогдох этгээдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ,

холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан асуултад хариулах байдлаар үр нөлөөний үнэлгээг хийхээр сонгов.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг холбогдох аргачлалын хүрээнд тооцон судлав.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн батлуулахад “зорилгод хүргэх байдал”, “практикт хэрэгжих боломж”, “хүлээн зөвшөөрөгдөх байдал” зардал гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой иргэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал үүсэхгүй тул “Зардал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

3.1. “Ойлгомжтой байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

3.2. “Харилцан уялдаа”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

3.1. “Зардал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ улсын төсөвт үүсэх зардал, ачаалал бага үүсгэх зохицуулалтын хувилбарыг боловсруулж, хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙЛАП

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон бөгөөд урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон аргачлалд тодорхойлогдсон дараах шалгах хэрэгслүүд байна.

Хүснэгт 1. Үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл |
|-----|-------------------|------------------------|---|
| 1 | Ойлгомжтой байдал | Хуулийн төсөл бүхэлдээ | Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28,29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах |
| 2 | Харилцан уялдаа | Хуулийн төсөл бүхэлдээ | Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах |
| 3. | Зардал | Хуулийн төсөл бүхэлдээ | Зардлын тооцоог хийх |

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”

Дээрх шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хангасан эсэхэд хариулт өгөх замаар төслийг бүхэлд нь шалгалаа.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн бүтэц, хэлбэрт нийцсэн байна.

Хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудаас ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн томъёоллын ойлгомжтой байдлын шаардлагад нийцсэн байна.

Хүснэгт 2. Ойлгомжтой байдлыг үнэлсэн байдал

| Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага | | |
|--|---|---|
| № | Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт | Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал |
| | | |

| | | |
|----|---|---|
| 1 | 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх; | Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдсан. |
| 2 | 29.1.2.тухай хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх; | Цөмийн материалыг энхийн зорилгоор ашиглаж буй эсэхийг баталгаажуулах талаар тусгасан. |
| 3 | 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх; | Хуулийн төсөлд тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй. |
| 4 | 29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх; | Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгаагүй. |
| 5 | 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх; | Нэг заалттай учир зөрчил үүсэхгүй. |
| 6 | 29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх; | Нэг удаа хэрэгжүүлэх заалт хуулийн төсөлд тусгаагүй. |
| 7 | 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх | Бусад хуулийн заалтыг давхардуулан заагаагүй. |
| 8 | 29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам; | Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журамд нийцсэн. |
| 9 | 29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт; | Эрх зүйн хэм хэмжээг зөрчих нөхцөл үүсэхгүй. |
| 10 | 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх; | Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй. |

30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

| | | |
|---|---|--|
| 1 | 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх; | Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэсэн. |
| 2 | 30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх; | Өөр өөр ойлголтыг нэг нэр томъёогоор илэрхийлээгүй. |

| | | |
|---|--|--------------------------------------|
| 3 | 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих; | Тус шаардлагад нийцүүлсэн. |
| 4 | 30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх; | Хүч оруулсан нэр томьёо хэрэглээгүй. |
| 5 | 30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх. | Тус шаардлагад нийцүүлсэн. |

Эх сурвалж:Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”

4.2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэхийг дараах байдлаар үнэллээ. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хүснэгт 3. Харилцан уялдааг үнэлсэн байдал

| № | Асуулт | Хариулт | Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал |
|---|--|---------|---|
| 1 | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх: | тийм | Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна. |
| 2 | Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх. | тийм | Энэхүү шаардлагад нийцүүлсэн. |
| 3 | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх | Тийм | Энэхүү шаардлагад нийцүүлсэн. |
| 4 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх. | тийм | Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно. |
| 5 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх | үгүй | Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй. |
| 6 | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх | тийм | Энэхүү шаардлагад нийцүүлсэн. |
| 7 | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх | үгүй | Энэхүү шаардлагад нийцсэн. |
| 8 | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх. | Үгүй | Энэхүү шаардлагад нийцсэн. |
| 9 | Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх | Үгүй | Төрийн байгууллагын зарим чиг үүргийг “мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага”-аар гүйцэтгүүлэх шаардлагагүй. |

| | | | |
|----|--|------|---|
| 10 | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх | Үгүй | Албан татвар, төлбөр, хураамж тогтоох шаардлагагүй. |
| 11 | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх | Үгүй | Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй. |
| 12 | Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх | - | Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй. |
| 13 | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх | - | Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой. |
| 14 | Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх | үгүй | Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй. |
| 15 | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх | үгүй | Тусгах шаардлагагүй. |

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал"

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд зориулж шалгах хэрэгслийг хэрэглэх явцад ашигласан мэдээлэл тоо баримт, дүгнэлт, холбогдох төрийн захиргааны төв байгууллагын санал зэрэг холбогдох бүх материалыг цуглуулсан бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үе шат бүрийг баримтжуулав.

Хуулийн төслийн үр нөлөөг ойлгомжтой байдал, уялдаа холбоо, зардал тооцох гэсэн шалгууруудаар үнэлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн хуулийн төсөлд тавигдах шаардлагыг хангасан гэж дүгнэхээр байна.

Үүнийг шалгуур тус бүрээр нарийвчлан авч үзвэл:

Хүснэгт 4. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

| № | Шалгуур | Дүгнэлт |
|---|-------------------|---|
| 1 | Ойлгомжтой байдал | Хуулийн төсөл батлагдсанаар манай улсад цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах үйл ажиллагааг цөмийн аюулгүй байдлын олон улсын хэм хэмжээ, шаардлагын дагуу нийцүүлэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Мөн Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэхэд олон талын дэмжлэг туслалцаа авах боломжтой болно. Тухайлбал, хууль эрх зүйн баримт бичиг боловсруулахад дэмжлэг, зөвлөмж авах, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааг гүйцэтгэх чадавхийг бий болгох, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийн тухай зөвлөх үйлчилгээ авах, хүний нөөцийг чадавхжуулах, дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах боломжтой болох юм. |

| | | |
|---|---------------|--|
| 2 | Уялдаа холбоо | Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдсан байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй. |
| 3 | Зардал | Протоколыг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг одоо ажиллаж байгаа хүний нөөцийн боломжид тулгуурлан, ажил үйлчилгээг хийж гүйцэтгэх боломжтой гэж тооцсон. Мөн протоколд нэгдэн орсноор цөмийн материалын анхны тайлан илгээх, протоколтой холбоотой хурал, зөвлөгөөнд оролцох үйл ажиллагаануудад ямар нэгэн зардал гарахгүй. |

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал"

Энэхүү хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулсан байна. Энэхүү Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон баталснаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал гарахгүй бөгөөд төсөвт ямар нэгэн ачаалал үүсэхгүй.

Монгол Улс бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон баталснаар цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргахтай холбоотой эрх зүйн чадамжийг бий болгож, Олон улсын хамтын нийгэмлэгийн улс орнуудын хэмжээнд нэр хүндээ дахин гаргаж ирэх, таатай боломж бүрдүүлэх юм.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орсноор Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх тухай статусыг цаашид урагшлуулан бэхжүүлэх, бүс нутгийн тогтвортой, аюулгүй байдлыг хангаж өөрийн орны онцлог, нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн аюулгүй байдлын баталгааг гүйцэтгэх, хянах техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийг бий болгох чиглэлээр Олон улсын атомын энергийн агентлагаас зохион байгуулах үйл ажиллагаанд хамрагдах, олон улсын экспертийн зөвлөх үйлчилгээ авах, хүний нөөцийг чадавхжуулах дадлагажих хөтөлбөрт хамрагдах зэрэг олон талын ач холбогдолтой юм.